

БАТЛАВ  
“РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ  
СҮЛЖЭЭ” УЛСЫН ТӨСӨВТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ



С. ЦАГААНХҮҮ

БАТЛАВ  
“ИНГЭТ ОРД КОНСТРАКШН”  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ



Б. ГАНСҮХ

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022.04.06

№

*Handwritten number: 1117245504*

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэнэ)-г нэг талаас “Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” Улсын Төсөвт Үйлдвэрийн Газрын Хангамж үйлчилгээний албаны дарга Э.Энхгэрэл (цаашид “Захиалагч” гэнэ), нөгөө талаас “Ингэт орд констракшн” ХХК-ний менежер У.Адъяа (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэнэ) (цаашид хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэнэ) нар Монгол улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон байгуулав.

#### 1. Нийтлэг заалт

1.1 Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн эзэмшлийн Хөвсгөл аймаг Мөрөн, Завхан аймаг Улиастай сумдад байрлах сайтын цамхгийн зэв, хуучин будгийг хусаж цэвэрлэх, бэхжүүлэгч түрхэх, зориулалтын будгаар будах, гарсан хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт хаях ажлыг гэрээнд заасан хугацаанд, төсөвт өртгөөр чанарын өндөр төвшинд хийж гүйцэтгэн актын дагуу Захиалагчийн өмчлөлд шилжүүлэх, ажлын гүйцэтгэлийн талаар Захиалагчийн эрх бүхий албан тушаалтанд тайлагнах, нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

#### 2. Гэрээний хугацаа

2.1 Энэхүү Гэрээ нь 2022 оны 04 дүгээр сарын 06-ний өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийг дуустал ажлын 30 хоногийн хугацаатай байна.

2.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

#### 3. Ажил үйлчилгээний төлбөр

3.1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт дүн 79 500 000 (далан есөн сая таван зуун мянган) төгрөг байна (Үүнд НӨАТ орсон болно).

3.2 Захиалагч тал Ажил гүйцэтгэгчид гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор ажил үйлчилгээний төлбөрийг Ажил гүйцэтгэгчийн Хаан банкны 5009342495 тоот дансанд шилжүүлнэ.

#### **4.Захиалагчийн эрх, үүрэг**

4.1 Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

4.2 Гэрээнд заасан хугацаа болон ажлын үр дүнг хүлээн авмагц ажил үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй.

4.3 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.

4.4 Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авснаас хойш аливаа эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

4.5 Ажил гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ зөрчиж ноцтой алдаа, дутагдал гаргасан болон хугацаа алдсан тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээг нэг талын санаачлагаар цуцлах ба өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

4.6 Захиалагч нь баталгаат хугацааны дотор ажлын үр дүнд доголдол илэрсэн тохиолдолд тухайн доголдлыг арилгуулахаар Ажил гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй.

4.7 Ажил гүйцэтгэлийн баталгаат хугацаа 12 сар байх ба тухайн хугацаанд гүйцэтгэсэн ажлын үр дүнд доголдолтой бол ажил гүйцэтгэгчийн зардлаар уг доголдлыг арилгуулах, эсхүл ажлыг шинээр гүйцэтгүүлэхээр шаардах эрхтэй.

#### **5.Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

5.1 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр төвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

5.2 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

5.3 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.

5.4 Дараах тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй:

- Ажил гүйцэтгүүлэхээр Захиалагчийн өгсөн зааварчилга, даалгавар нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;
- Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон.
- Ажил гүйцэтгэгч нь өөрийн инженер техникийн ажилчдын ХАБ ЭА-г бүрэн хариуцаж ажиллана


5.5 Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаар хариуцан арилгах үүрэгтэй.

- 5.6 Захиалагчид өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх үүрэгтэй.  
5.7 Ажлын үр дүн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг хариуцах үүрэгтэй.  
5.8 Ажил гүйцэтгэгч нь ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу шаардах эрхтэй.  
5.9 Ажил үйлчилгээний даалгаврын талаархи аливаа мэдээллээр хангагдах эрхтэй.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагч талыг төлөөлж:

Хангамж, үйлчилгээний албаны дарга

...../Э.Энхгэрэл/

Хаяг: БГДүүрэг 17-р хороо Амарсанаагийн  
гудамж  
Утас : 75112020

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

Менежер

...../У.Адъяа/

Хаяг: ЧДүүрэг 13-р хороолол,  
сургуулийн 1-3 тоот  
Утас: 89098797



Хөвсгөл, Завхан аймгийн мачит цамхаг будах

Төсөвт өртгийн нэгдсэн товчоо

№	Зардалын нэр	Бүгд өртөг/төгрөг
1	Ажиллах хүчний зардал	22,000,000
2	Материал	28,000,000
3	Тээвэр	3,500,000
4	Машин ашиглалт	4,535,000
Шууд зардалын дүн		
5	Ашиг 15%	11,925,000
Барилгын ажлын зардал		
6	НӨАТ 10%	7,950,000
	Дүн	77,910,000
7	Магадлашгүй зардал 2%	1,590,000
8	Бусад зардал	0
	Дүн	79,500,000

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Б.ГАНСҮХ